



Б Н М А У

УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН ХУРЛЫН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ ТОГТООЛ

1991 оны 12 сарын 24

№ 36

Улаанбаатар
хот

УЛСЫН ҮЙЛДВЭРИЙН ГАЗАР БАЙГУУЛАХ
ТУХАЙ

Улаанбаатар хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргаанаас
ТОГТООХ нь:

1. БНМАУ-ын аж ахуйн нэгжийн тухай хуулийг үндэслэн Хот тохижуулах байгууллагуудын одоогийн гүйцэтгэж байгаа ажил үйлчилгээг хэвээр үлдээж Хот цэцэрлэгжүүлэх трестийг "Цэцэрлэгжилт" компани /УУГ/, Хоёрдогч түүхий эдийн конторыг "Нөөц" компани /УУГ/, Гэрэлтүүлэг чимэглэлийн үйлдвэрийг "Гэрэлтүүлэг чимэглэл" компани /УУГ/, Хот тохижилтын трестийг "Тохижилт" компани /УУГ/, дүүргүүдийн тохижилт үйлчилгээний трестүүдийг "Тохижилт үйлчилгээний 1,2,3,4 компани /УУГ/, Зуслангийн товчоог "Зуслан" компани /УУГ/ болгон тус тус байгуулсугай.

2. Хот тохижилтын бодлого боловсруулан хэрэгжүүлэх, нийтийн эзэмшдийн бүс дэх аж ахуйн ашиглалт, тохижилт цэцэрлэгжилт, гэрэлтүүлэг реклам, хог хаягдлын цэвэрлэгээ тээвэрлэлт, мод цэцэг ургамал үржүүлэлт, тариалалтын ажилд техник технологийн хяналт тавих зураг төсвөөр хангах тэдгээрт зарах хөрөнгийг төвлөрүүлэн үр ашигтай зарцуулах материал хангамж, ажиллагсдын мэдлэг мэргэжлийг дээшлүүлэх зэрэг асуудлыг хотын АХГЗ-ны нэрийн өмнөөс гүйцэтгэх үүргийг Хот тохижуулах газарт хариуцуулсугай.

3. Хот тохижуулах газрын дүрмийг I-р хавсралтаар баталж, өөрийн удирдлагад ажиллах ба компаниудын дүрмийг баталж өгөхийг Хот тохижуулах газар /н.Отгонсүрэн/-т зөвшөөрсүгэй.

4. Улаанбаатар хотын Хот тохижуулах байгууллагууд /УУГ/-ын дарга нарыг томилон, тэдэнтэй гэрээ байгуулж ажиллахыг Хот тохижуулах газар /н.Отгонсүрэн/-т зөвшөөрсүгэй.

5. Улсын үйлдвэрийн газрын жагсаалт батлах тухай Улаанбаатар хотын АХГ захиргааны 1991 оны 230 дугаар тогтоолын I дүгээр хавсралтанд Хоёрдогч түүхий эдийн конторыг намж оруулсугай.

6.Хот тохижуулах газрын харьяа зураг төсвийн товчоог татан буулгаж хоршоо болгосугай.

7.Хот тохижуулах газрын орон тос цалингийн фондыг хянаж батлахыг санхүүгийн газар /н.Гонгор/-т даалгасугай.

8.Энэ тогтоол гарсантай холбогдож Улаанбаатар хотын АДХ-ын гүйцэтгэх захиргааны 1987 оны 2-р сарын 29-ны II4, 1990 оны II-р сарын 29-ны 310-р тогтоолын I,2-р заалт, 1991 оны 86-р тогтоолын 2I-р хавсралт, АХ-ны гүйцэтгэх захиргааны 1991 оны 2-р сарын 07-ны 48-р тогтоолын I,2,3-р заалтыг тус тус хүчингүй болгосугай.



УВ.ХОТЫН АХ-ЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ

ДАРГА

[Handwritten signature]

Л.ЭНЭБИШ

ХЭРЛЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН

ДАРГА

[Handwritten signature]

Ц.БОЛДСАЙХАН



Улаанбаатар хотын АХ-ын гүйцэтгэх захиргааны 1991 оны 12-р сарны 24-н өдөр 261 тогтоолна хавсралт

УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН ХУРЛЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ ХОТ ТОХИЖУУЛАХ ГАЗРЫН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Хот тохижуулах газрын гол зорилт нь хот тохижуулалт, цэцэрлэгжилт, гэрэлтүүлэг, реклам чимэглэл, хотын ариун цэвэр, соёлжилтыг сайжруулан үйлдвэр үйлчилгээний төлөвлөлтийг улам боловсронгуй болгож, шинжлэх ухаан техник технологийн ололтыг нэвтрүүлж, хот тохижилтын ажлын чанар үр дүнгийн еөрчлөлт гаргах, бодлого боловсруулан хэрэгжүүлэх замаар нийслэл хотоо хөдөлмөрчдийн ажиллаж амьдрахад аятай нөхцлийг бүрдүүлсэн бүрэн тохижилттой хот болгоход оршино.

2. Хот тохижуулах газар нь Улаанбаатар хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргааны шууд удирдлагын дор "Цэцэрлэгжилт", ТҮА компани, "Хот тохижилт", "Зуслан", "Гэрэлтүүлэг чимэглэл", "Тохижилт үйлчилгээ 1,2,3,4, "Нөөц" компаниудыг мэргэжлийн удирдлагаар хангаж тэдний ажлыг уялдуулан зохион байгуулж, зураг төсвөөр хангах, шинэ бүтээл, оновчтой санал тэргүүн туршлага нэвтрүүлэх, техник технологийн горим, ажлын чанар, санхүүгийн үйл ажиллагааны хяналт тавьж батлагдсан төсөвт хөрөнгийг үр амьттай зарцуулна.

3. Хот тохижуулах газар нь үйл ажиллагаандаа БНМАУ-ын хууль тогтоомж, энэ дүрэм болон эрх зүйн бусад шийдвэрийг удирдлага болгоно.

4. Хот тохижуулах газар нь хотын АХ-ын гүйцэтгэх захиргаанд ажлаа тайлагнана.

5. Хот тохижуулах газар нь тогтоосон журмын дагуу хийгдсэн өөрийн албан бичгийн хуудас, тамга, тэмдэг хэрэглэнэ.

6. Хот тохижуулах газрын даргыг Хотын АХ-ын гүйцэтгэх захиргаанаас томилж тусгай гэрээтэй ажиллуулна.

7. Хот тохижуулах газрын даргыг гэрээний биелэлтийг харгалзан албан тушаалаас чөлөөлөхийг Хотын АХ-ын гүйцэтгэх захиргаа шийдвэрлэнэ.

8. Хот тохижуулах газрын дарга нь эрх хэмжээнийхээ асуудлаар тушаал гаргана.

9. Газрын ажилтан ажилчдыг хөдөлмөрийн гэрээний үндсэн дээр томилж чөлөөлөх асуудлыг газрын даргын тушаалаар шийдвэрлэнэ.

10. Байгууллагын ажил үйлчилгээний холбогдолтой асуудлаар гадаад орнуудтай холбоо тогтоон ажиллана.

11. Хот тохижуулах газар нь "Цэцэрлэгжилт", ТУА компани, Нөөц, Хот тохижилт, Зуслан, Гэрэлтүүлэг чимэглэл, Тохижилт үйлчилгээ 1, 2, 3, 4 компаниудын дүрмийг батлаж дарга нарыг гэрээний үндсэн дээр томилж ажиллуулна.

Хоёр. Хот тохижуулах газрын гүйцэтгэх үүрэг

1. Хотын ерөнхий төлөвлөгөөний дагуу жил бүрийн тохижилтын ажлыг төлөвлөж боловсруулан батлуулж, хөрөнгө оруулалтын захиалагчийн үүргийг гүйцэтгэн, тохижилтонд өгөгдсөн хөрөнгийг үр ашигтай зарцуулах.

2. Хот тохижуулах салбарын материаллаг баазыг бэхжүүлэх, материал техник хангамж, боловсон хүчний болон гадаад харилцааны асуудлыг харилцан зохион байгуулах.

3. Хот нийтийн эд аж ахуй, гудамж талбай, ногоон байгууламжийн цэвэрлэгээ, тэдгээрийн ашиглалт /бүрэн бүтэн байдалд/ Гэрэлтүүлэг рекламн асалт хог хаягдал тээвэрлэлтэнд хяналт тавьж, шаардлагатай арга хэмжээг тухай бүр авч зохион байгуулна.

4. Хот тохижуулах ажилд байгууллага иргэдийг өргөн оролцуулан идэвхжүүлэхэд уралдааныг өрнүүлж, шинэ техник технологи, дэвшилтэт арга ажиллагааг нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах.

5. Хот тохижуулах ажлын норм, үнэлгээг шинэчлэх, тогтоох хөдөлмөр зохион байгуулалтыг олохсонгогуй болгох зэрэг асуудлыг боловсруулж шийдвэрлүүлэх, бтөлэлтэнд хяналт тавих

6. Хот тохижуулах салбарыг мэргэжлийн удирдлагаар ханган тэдгээрийн үйл ажиллагаанд хяналт тавих.

7. Хот тохижуулалтын ажил үйлчилгээний болон санхүү ажийн засгийн тайлан мэдээг батлагдсан хуваарийн дагуу шуурхай үнэн зөв гаргаж байх.

3.

8. Хот тохижуулах ажил үйлчилгээг тодорхой гэрээний үндсэн дээр явуулж дүгнэх, хүлээн авах.

9. Хөдөлмөрчдийн санал гомдлыг хүлээн авч шийдвэрлэх

Гурав. Хот тохижуулах газрын эдлэх эрх

1. Хот тохижуулах байгууллагын ажлыг мэргэжлийн үүднээс шалган зааварлах, тэдгээр байгууллагын даргын томилж гэрээтэй ажиллуулах, ажил үйлчилгээний талаар холбогдох ажилтны илтгэл сонсгол авч хэлэлцэн үүрэг даалгавар өгөх биелэлтэнд хяналт тавих.

2. Хот тохижилтонд өгөгдсөн бүх мөнгөн хөрөнгийг зохих журмын дагуу зарцуулах

3. Хот тохижилт, нийтийн эзэмшлийн эд аж ахуйн ашиглалтанд хяналт тавьж илэрсэн зөрчил, дутагдалд торгууль тавих, эдлэх эрхийг хасах асуудал боловсруулан шийдвэрлүүлэх, хугацаат үүрэг өгч дутагдлыг арилгуулах зэрэг арга хэмжээ авах.

4. Хот тохижуулах ажилд байгууллага хөдөлмөрчдөөс гарч буй үүсгэл санаачлагыг өрнүүлэхэд уралдаан зарлан дүгнэх, үзүүлэх сургууль явуулах, зөвлөлгөөн, ярилцлага хийх.

Энэхүү дүрмийг хэрэгжүүлэхэд газрын дотоод журам боловсруулан мөрдөнө.

Хот тохижуулах газар улсын бүртгэлд бүртгүүлсэн өдрөөс эхлэн ажлаа /хүчин төгөлдөр/ явуулж эхэлнэ.